

**“СИЛК НЭТ” ХК  
ТООЛЛОГЫН КОМИССЫН  
ТОГТООЛ**

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 02/01

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ БОЛОН  
ХУРЛЫГ ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 337,624 ширхэг хувьцаа эзэмшдэг дөрвөн хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 374,018 ширхэг энгийн хувьцааны 90,2% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 90,2% -ийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА *Б.Батцэцэг* Б.БАТЦЭЦЭГ



## **“СИЛК НЭТ” ХК** **ТООЛЛОГЫН КОМИССЫН** **ТОГТООЛ**

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 02/02

Улаанбаатар хот

### **Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай**

Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 дах заалт, 72-р зүйл, “Силк Нэт” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 4-р сарын 30-ны өдрийн ээлжит хуралд санал хураалтаар ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Силк Нэт” ХК– ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй:

Үүнд:

- 1.1 Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах  
Зөвшөөрсөн 337,624 ширхэг хувьцаа буюу 100 %, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
- 1.2 Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон бусад төсөл төлөвлөгөөг батлах  
Зөвшөөрсөн 337,624 ширхэг хувьцаа буюу 100 %, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
- 1.3 Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах  
Зөвшөөрсөн 337,624 ширхэг хувьцаа буюу 100 %, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
- 1.4 Бусад  
Зөвшөөрсөн 337,624 ширхэг хувьцаа буюу 100 %, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА** *Батцэцэг* **Б.БАТЦЭЦЭГ**



# **“СИЛК НЭТ” ХК ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 02/03

Улаанбаатар хот

## **САНАЛ ХУРААХ ХУУДСЫГ ТООЛСОН ДҮНГИЙН ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дах заалт, 72.1.3 болон 75.4 дэх хэсэг, санал хураах хуудсаар кумулятив аргаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр кумулятив аргаар өгсөн саналын тоо нь дараах байдалтай байгааг хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлсүгэй. Үүнд:

№	ТУЗ-ийн гишүүд	Саналын тоо	Саналын,%
Ердийн гишүүд			
1	Ц.Сарантуяа	337,624	100%
2	Г.Алтаймаа	337,624	100%
3	Б.Онон	337,624	100%
4	Р.Саидаброр	337,624	100%
5	Эльер Хасанов	337,624	100%
6	Э.Саранчимэг	337,624	100%
Хараат бус гишүүд			
7	Г.Энхбат	337,624	100%
8	Б.Хосбаяр	337,624	100%
9	Н.Баярмаа	337,624	100%

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА *Дамсжав* Б.БАТЦЭЦЭГ



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 03/01

Улаанбаатар хот

**ДҮГНЭЛТ, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2020 оны 4 сарын 30-ны өдрийн тооллогын комиссын 02/02 -р тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компанийн 2020 онд хэрэгжүүлэхээр танилцуулсан төсөл, төлөвлөгөөг батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**М.САЙНБОЛОР**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 03/02

Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ  
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2020 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн үйл ажиллагаа өнгөрсөн санхүүгийн жилд хөрөнгө оруулалтаас шалтгаалан тогтвортой биш, ашиггүй байсан тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн болохыг хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 03/02

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2020 оны 4-р сарын 30–ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ц.Сарантуяа
2. Б.Онон
3. Р.Сайдаброр
4. Г.Алтаймаа
5. Эльер Хасанов
6. Э.Саранчимэг

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Г.Энхбат
2. Б.Хосбаяр
3. Н.Баярмаа

3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**М.САЙНБОЛОР**